



САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2024 оны 6 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар А/118

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.6 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

- 1."Нээлттэй тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулах журам"-ыг хавсралтаар баталсугай.
- 2.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан "Журам батлах тухай" Сангийн сайдын 2019 оны 208 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
- 3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар (Ж.Дэлгэржаргал), Санхүүгийн бодлогын газар (Л.Соноор), Хууль, эрх зүйн газар (З.Энхболд)-т тус тус үүрэг болгосугай.

САЙД Б.ЖАВХЛАН